

БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ, ЗАСАГЛАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН – 2025 ОН

1	Үнэт цаас гаргагчийн нэр			"ТАВАНТОЛГОЙ" ХК		
2	Үнэт цаас гаргагчийн код (МХБ-ийн симбол)			ТТЛ		
3	Салбар/үйлдвэрлэл (МХБ-ийн салбар ангилал)			УУЛ УУРХАЙН ОЛБОРЛОЛТ, БОРЛУУЛАЛТ		
4	Тайланд орсон компаниуд (энэхүү тайланд орсон толгой болон охин компаниудын мэдээлэл)			-		
5	Тайлангийн хамрах хугацаа			2025.01.01-2025.12.31		
6	Хариуцсан албан тушаалтны овог нэр, албан тушаал, холбоо барих имэйл хаяг, утас			ТУЗ-ЫН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА Б.БОЛДБАЯР /88106697/, info@tavantolgoi.mn		
7	Тайланг баталгаажуулсан Төлөөлөн удирдах зөвлөлийн даргын мэдээлэл (нэр, албан тушаал)			Б.МЭНДБАЯР ТУЗ-ЫН ДАРГА ТАВАНТОЛГОЙ ХК		
8	Төлөөлөн удирдах зөвлөлийн даргын гарын үсэг			 		

Код	Ангилал	Шалгуур үзүүлэлт	Шалгуур үзүүлэлтийн тайлбар	Үзүүлэлт, хэмжих нэгж	Үзүүлэлт 2025	Нэмэлт мэдээлэл
MS	ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН УДИРДЛАГЫН СИСТЕМТЭЙ ХОЛБООТОЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ					
MS1.1	Тогтвортой хөгжлийн удирдлагын систем	Удирдлагын амлалт	Удирдлагаас баталсан тогтвортой хөгжлийн амлалт, мэдэгдэл байдаг эсэх	Тийм/Үгүй	Тийм	Тавантолгой ХК нь "Нэгдмэл, уян хатан, шинийг санаачлагч, дэвшилтэт техник технологийг нэвтрүүлдэг, тасралтгүй суралцдаг байгууллага байх" алсын хараагаа хэрэгжүүлэх замаар НҮБ-ын тогтвортой хөгжлийн зорилтуудын хэрэгжилтэд хувь нэмэр оруулахыг зорин ажилладаг. Энэхүү алсын хараа нь ажилтнуудын мэдлэг, ур чадварыг тасралтгүй хөгжүүлэх (ТХЗ 4), бүтээмжтэй, зохистой хөдөлмөрийг дэмжих (ТХЗ 8), инноваци болон дэвшилтэт технологийн хэрэглээг нэмэгдүүлэх (ТХЗ 9), үйлдвэрлэлийн үр
MS2.1		Тогтвортой хөгжлийн бодлого, зохицуулалт	Тогтвортой хөгжлийн бодлого, зорилтуудыг тодорхойлж баталсан эсэх	Тийм/Үгүй	Тийм	

					ашиг, нөөцийн зохиистой хэрэглээг сайжруулах (ТХЗ 12), уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг үр ашигтай технологийг нэвтрүүлэх (ТХЗ 13), мөн байгууллагын болон оролцогч талуудын хамтын ажиллагааг бэхжүүлэх (ТХЗ 17) зорилтуудтай уялдаж байна.
MS2.2		Тогтвортой хөгжлийн журам байдаг эсэх	Тийм/Үгүй	Үгүй	
MS3.1		Танай тогтвортой асуудал хариуцсан хороо байдаг эсэх	Тийм/Үгүй	Үгүй	
MS3.2		ТУЗ-ын тогтвортой хөгжил / БОНЗ-ын асуудал хариуцсан (бүтэн цагийн/хавсран) байдаг эсэх	Тийм/Үгүй	Тийм	Компанийн тогтвортой хөгжлийн засаглалыг бэхжүүлэх зорилгоор Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэд БОНЗ /Тогтвортой хөгжлийн асуудал хариуцсан хороо/ байгуулж ажиллуулах төлөвлөж байна. Тус хороо нь БОНЗ-ын бодлого, зорилт, стратегийг тодорхойлох, хэрэгжилтэд хяналт тавих, байгаль орчин, нийгмийн хариуцлага, засаглалын чиглэлээрх эрсдэл, үзүүлэлт, тайлангалын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах чиг үүрэгтэй байхаар төлөвлөн ажиллаж байна.
MS3.3	Бүтэц удирдлага	Гүйцэтгэх удирдлагын түвшинд /БОНЗ-ын асуудал хариуцсан (бүтэн цагийн/хавсран) байдаг эсэх	Тийм/Үгүй	Тийм	БОНЗ тайлангийн Байгаль орчны шалгуур үзүүлэлт дэх эрчим хүчний үзүүлэлтүүдийг Уурхайн төлөвлөлт, ашиглалтын хэлтэс, Хүлэмжийн хийн ялгараг, уур амьсгалын өөрчлөлт, ус, хатуу хог хаягдал, биологийн олон янз байдал хэсгүүдийн шалгуур үзүүлэлтүүдийг Байгаль орчны алба, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шалгуур үзүүлэлтүүдийг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хэлтэс, Хүний нөөц, эрх тэгш байдал, хүртээмжтэй байдал, нийгмийн хариуцлага ба олон нийтийн оролцоо, авлига болон ёс зүйн шалгуур үзүүлэлтүүдийг Захиргаа, удирдлагын газар, Тогтвортой өртгийн сүлжээний менежментийн шалгуур үзүүлэлтийг Худалдан авалт, хангамжийн хэлтэс тус тус хариуцан ажиллаж байна.
MS3.4		Үйл ажиллагааны түвшинд /БОНЗ-ын асуудал хариуцсан (бүтэн цагийн/хавсран) байдаг эсэх	Тийм/Үгүй	Тийм	

MS3.5		Танай компани ТУЗ-ийн хурлын хөтөлбөрт тогтвортой хөгжлийн асуудлыг албан ёсоор тусгадаг эсэх	Тийм/Үгүй	Тийм	Нүүрсний ил уурхайн ашиглалтын үйл ажиллагааны тайлан, Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан, Ус ашиглалтын тайлан, Хамтын ажиллагааны гэрээний хэрэгжилт зэргийг ээлжит хурлуудын хөтөлбөрт тусгаж хэлэлцдэг.
MS4.1	Тогтвортой байдлын нөлөөллийн үнэлгээ	Танай компани эдийн засаг, байгаль орчин, нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөллөөс хэрхэн зайлсхийх, бууруулах, арилгах, зөрөг үр нөлөөг сайжруулах талаар тайлбарласан нөлөөллийн үнэлгээ эсвэл матриц байдаг эсэх	Тийм/Үгүй	Тийм	Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээг тогтмол хийлгэж, гүйцэтгэлийг тайлагнан ажилладаг.
MS5.1	Чадавх бүрдүүлэлт	Нэг ажилтанд ногдох тогтвортой хөгжлийн тухай сургалтын жилийн дундаж цаг, хүйсээр	Тийм/Үгүй	Тийм	"Тэрбум мод" үндэсний хөтөлбөрийн хүрээнд байгаль орчноо хамгаалах, говь нутгийн цөлжилтөөс урьдчилсан сэргийлэх, байгууллагын Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах зорилгоор 4, 10 дугаар саруудад тус бүр бүтэн өдөр буюу ажлын 8 цагийн мод, бут тарих ажлыг зохион байгуулдаг бөгөөд 2025 он хайлаас модны үрийг үрслүүлэх сургалтад ажилчдыг хамруулж, мэдлэг олгож, дэдлэгжүүлсэн.
MS6.1	Хяналт	Тогтвортой байдлын асуудал нь Аудитын хорооны үйл ажиллагаа, дотоод хяналтын чиг үүрэгт хамаардаг уу?	Тийм/Үгүй	Үгүй	Тогтвортой байдлын асуудлаарх шийдвэр, үйл ажиллагааны гүйцэтгэл, хэрэгжилтийг тодорхойлох, үнэлэлт дүгнэлт өгөх асуудал нь ТУЗ-ын дэргэдэх Аудитын хороо, Дотоод хяналтын хэлтсийн чиг үүрэгт хамаардаг.
MS7.1	Тогтвортой хөгжлийн удирдлагын систем	Тогтвортой байдлын тайланг доошгүй тайлагнадаг уу?	Тийм/Үгүй	Үгүй	2025 оноос тус тайланг тайлагнаж ажиллахыг хэвшил болгон ажиллаж байна.

MS7.2	Тогтвортой хөгжлийн удирдлагын систем		Танай компани олон улсын уур амьсгалын эрсдэлийг олон улсын стандарт (УАӨСМТАХ, БОТСМТАХ)-ын дагуу тайлагнадаг уу?	Тийм/Үгүй	Үгүй	Одоогоор уур амьсгалын эрсдэлийн тайлагналыг УАӨСМТАХ (ТСFD), БОТСМТАХ (TNFD)-ын шаардлагад бүрэн нийцүүлэн хэрэгжүүлээгүй байна. Харин БОНЗ тайлагналд GRI стандарт болон олон улсын сайн туршлагад тулгуурлан байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой мэдээллийг тусган тайлагнаж байна. Цаашид уур амьсгалын эрсдэлийн үнэлгээ, эрсдэлийн удирдлага, тайлагналын тогтолцоог ТСFD болон TNFD-ийн зөвлөмжид нийцүүлэн үе шаттайгаар хөгжүүлэхээр төлөвлөж байна. Уур амьсгалын эрсдэлийн тайлагналыг ТСFD, TNFD-ийн шаардлагад бүрэн нийцүүлэн хэрэгжүүлээгүй боловч GRI стандартын дагуу холбогдох мэдээллийг тайлагнаж, олон улсын аргачлалд нийцүүлэхээр ажиллаж байна
MS7.3			Тогтвортой хөгжлийн болон БОНЗ-ын мэдээллийг хөндлөнгийн байгууллагаар баталгаажуулдаг уу?	Тийм/Үгүй	Үгүй	
MS8.1		Гишүүнчлэл, хамтын ажиллагаа	Танай компани тогтвортой хөгжлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг олон улсын болон дотоодын холбоо, нэгдэлтэй хамтран ажилладаг уу?	Тийм/Үгүй	Тийм	Манай байгууллагын 51% орон нутгийн өмч тул Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хүрээнд аливаа ажил үйлчилгээ, хамтын ажиллагааг хэрэгжүүлэхэд нээлттэй сонгон шалгаруулалтыг явуулж ажилладаг тул тухайн үед шалгарсан аж ахуйн нэгж, байгууллагатай хамтран ажилладаг. Харин энэ чиглэлээр урт хугацааны хамтын ажиллагааг эхлүүлээгүй байна.
E		БАЙГАЛЬ ОРЧНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД				
E1.1	Эрчим хүч	Нийт эрчим хүчний хэрэглээ	Эрчим хүчний нийт зарцуулалтын болон зардал	кВт.ц сая.төг	480,900 137,38	Тайлант хугацаанд нийт эрчим хүчний хэрэглээг төвийн эрчим хүчний системээс авсан 432,750 кВт.ц цахилгаан эрчим хүч болон дотоодын хэрэглээнд ашигласан 540 кВт.ц хучин чадалтай нөөц генераторын 4,500 литр дизель түлшний хэрэглээг (48,150 кВт.ц) нэгтгэн тооцсон. Нийт 480,900 кВт.ц/жил.

E1.2	Цахилгаан	Цахилгааны зарцуулалтын нийт хэмжээ болон хэмнэлт (жилээр)	кВт.ц	432.75	Компанийн цахилгаан эрчим хүчний хэрэглээг Төвийн эрчим хүчний системээс (ТЭХС) хангадаг. Цахилгаан хангамжийг уурхайн зориулалттай 100 кВА-ын АТП, 250 кВА-ын КТПН, оффисын зориулалттай 400 кВА-ын КТПН болон 250 кВА-ын КТПН-ээр дамжуулан хангаж байгаа бөгөөд 2025 онд хэрэглэсэн цахилгааны төлбөр 123,3 сая.төг болсон.
			сая.төг	123,33	Мөн дотоодын хэрэглээнд 540 кВА-н нөөцийн генератор ашиглаж байна. Генераторт ашигласан түлшний хэмжээ 4320 литр, нийт цахилгааны хэрэглээ 650 кВт байна.
E1.3	Дулаан	Дулааны зарцуулалтын нийт хэмжээ болон хэмнэлт (жилээр)	Гкал ба Гдж - Гержоуль зэвэл кВт.ц	-	Цогцэцуй сумын төв дэх оффис болон Улаанбаатар хот, Өмнөговь аймаг дахь Төлөөлөгчийн газруудын дулаан хангамжийн зардал нь түрээсийн төлбөрт багтдаг тул задалж тооцоолоогүй болно. Уурхай талбай дахь жижиг оффисын болон амралтын өрөө талбайнууд нь цахилгаан эрчим хүчээр халдаг тул цахилгааны зардалд тооцоглогдсон.
E1.4	Түлш	Түлшний зарцуулалтын нийт хэмжээ болон хэмнэлт (жилээр)	Литр/кг & %, ГЖоуль, төгрөг	Дизель түлш 370,406.27литр	Тайлант хугацаанд нийт 370,406.27 литр дизель түлш хэрэглэсэн. Үүнээс дотоодын цахилгаан хангамжийн найдвартай ажиллагааг хангах зорилгоор ашигладаг 540 кВА хүчин чадалтай нөөц,генераторт 4,320 литр (14.05 сая төгрөг)-ийн дизель түлш зарцуулсан бөгөөд генераторын нийт цахилгаан үйлдвэрлэх хүчин чадал 650 кВт байна.
					Үлдсэн 366,086.27 литр дизель түлшийг уурхайн үндсэн үйл ажиллагаанд ашиглагддаг техник, тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг хангахад зарцуулсан.
E1.5	Хүрэн эрчим хүч	СЭХ-ээс бусад эх үүсвэрээс авсан эрчим хүчний хэрэглээний хувь	%	100	Тайлант хугацаанд компанийн эрчим хүчний хэрэглээ нь сэргээгдэх бус эх үүсвэрээс хангагдсан бөгөөд төвлөрсөн эрчим хүчний систем болон шаардлагатай үед дизель генератор ашигласан.
E1.6	Сэргээгдэх эрчим хүч	СЭХ үүсвэрээс гаргаж авсан эрчим хүчний хэрэглээний хувь	%	-	Тайлант хугацаанд сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр ашиглаагүй бөгөөд хэрэглээний зэлэх хувь 0% байна.

E2.1	Хүлэмжийн хийн ялгарулалт	Компанийн шууд ба шууд бус үйл ажиллагаанаас ялгарсан нийт хүлэмжийн хийн дүн	CO2/тонн	1,295.62	Компанийн хүлэмжийн хийн ялгарлыг GHG Protocol аргаар дараах байдлаар тооцож, Score 1 болон Score 2 ялгарлыг хамруулсан. Тайлант хугацаанд дизель түлшний хэрэглээнээс 992.69 тCO ₂ е, Төвийн эрчим хүчний системээс хэрэглэсэн цахилгаан эрчим хүчнээс 302.93 тCO ₂ е ялгарал тооцогдож, нийт хүлэмжийн хийн ялгарал 1,295.62 тCO ₂ е байна. Тооцоонд дизель түлшний 2.68 кг CO ₂ е/литр, цахилгаан эрчим хүчний 0.0007 тCO ₂ е/кВт.ц ялгарлын коэффициентийг ашигласан.
E2.2	Хүлэмжийн хийн ялгарал	Буйруулсан хүлэмжийн хий	CO2/тонн	-	Хүлэмжийн хийн ялгарлын бууруулалтын тооцоолол хийгдээгүй.
E2.3	Дүйцүүлэх арга хэмжээ /Карбон офсет/	Нийт карбон офсет буюу дүйцүүлэх арга хэмжээний (мод тарих хөтөлбөр, хүлэмжийн бууруулах төслийг дэмжих гэх мэт) бууралт	CO ₂ е/жил	956тн	Компани нь Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутаг дэвсгэрт хамгаалалтын ойн зурвас байгуулах хүрээнд нийт 46 га талбайд (40 га болон 6 га) 4-6 настай 95,000 ширхэг хайлаас мод тарьж, усалгаа, арчилгаа, хамгаалалт, нөхөн тарилтын ажлыг төлөвлөгөөний дагуу тогтмол хэрэгжүүлсэн. Тайлант хугацаанд тарьцын амьдралтыг сайжруулах зорилгоор 3,000 ширхэг суулгацаар нөхөн тарилт хийсэн. Тарьсан модны төрөл, насжилт, тоо хэмжээ болон ашигласан тооцооллын аргаар үндэслэн хийсэн урьдчилсан үнэлгээгээр 2025 онд хэрэгжүүлсэн ойжуулалтын арга хэмжээний үр дүнд ойролцоогоор 956 тн CO ₂ е хэмжээний нүүрстөрөгч шингээх боломж бүрдсэн гэж тооцогдсон.
E3.1	Уур амьсгалын өөрчлөлт	Уур амьсгалын бодлого, журам	Танай компани уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг тусдаа эсвэл бусад журамд тусгасан бодлоготой юу?	Тийм/Түий	Тийм

Компанийн тодорхойлсон алсын хараад тогтвортой хөгжлийн инноваци болон дэвшилтэт технологийн хэрэглээг нэмэгдүүлэх (ТХЗ 9), үйлдвэрлэлийн үр ашиг, нөөцийн зохистой хэрэглээг сайжруулах (ТХЗ 12), уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг үр ашитай технологийг нэвтрүүлэх (ТХЗ 13), мөн байгууллагын болон ороолгогч талуудын хамтын ажиллагааг бэхжүүлэх (ТХЗ 17) зорилтуудыг агуулдаг бөгөөд

					Уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг бодлогыг компанийн бусад бодлогуудтай уялдуулан тодорхойлсон Мөн компани нь Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний (БОНН) хүрээнд жил бүр Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулан батлуулж, уурхайн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэх, нөхөн сэргээх арга хэмжээг хэрэгжүүлэн ажиглаж байна.
E3.2	Уур амьсгалын эрсдэл ба боломжийн үнэлгээ	Танай компани уур амьсгалын эрсдэл, боломжийн талаарх үнэлгээ хийсэн үү? (сценарийн шинжилгээ, стресс тест гэх мэт)	Тийм/Үгүй	Үгүй	Тайлант хугацаанд уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой эрсдэл, боломжийн талаар сценарийн шинжилгээ, стресс тест зэрэг олон улсын аргачлалд суурилсан үнэлгээ хийгдээгүй.
E3.3	Эдийн засгийн хохирол	Уур амьсгалын өөрчлөтөөс үүдэлтэй гамшиг, үйл явдлын улмаас учирсан эдийн засгийн нийт хохирлын үнэлгээ	Тийм/Үгүй	Үгүй	Тайлант хугацаанд уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй гамшиг, онцгой үйл явдлын улмаас компанид учирсан эдийн засгийн хохирол бүртгэгдээгүй тул холбогдох хохирлын үнэлгээ хийгдээгүй байна.
E3.4	Уур амьсгалын хөрөнгө оруулалт	Уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг дэд бүтэц, дасан зохицол, бүтээгдэхүүн хөгжидцлд оруулсан хөрөнгө оруулалтын дүн	Төгрөг	265,4 сая.төг	"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнд нэгдэн, 2022-2030 онд 7,5 сая мод тарих амлалт авсан. 2025 онд тус аймгийн Цогтцацуй, Даланзадгад, Номгон, Дундговь аймгийн Луус сумд, Улаанбаатар хот, мөн "Шинэ Хархорин хот" болон "Шамбала-2056" төслүүдэд өөрийн үржүүлгийн газарт бэлтгэсэн 170,000 орчим мод, модны суулгац нийлүүлж, суулгаж, ойжуулалтын үйл ажиллагааг дэмжсэн. Тэмдэглэл: Мод, суулгацны тооцоолсон эдийн засгийн үнэлгээ нь нэг хайлгаасны үрсэлгээний үнийг 1,000 төгрөгөөр тооцсон. Мөн 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хүрээнд сөрөг нөлөөллийг бууруулах 15, нөхөн сэргээлтийн 2, биологийн олон янз байдлыг хамгаалах 4, хог хаягдлын менежментийн 7, удирдлага зохион байгуулалтын 11 арга хэмжээ болон орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлж,

						нийт 95,421,058 төгрөг зарцуулсан байна. Эдгээр арга хэмжээ нь уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулах, дасан зохицох чадавхыг нэмэгдүүлэхэд хувь нэмэр оруулсан.
E3.5		Уур амьсгалын өөрчлөлтөөс урьдчилан сэргийлэх эсвэл дасан зохицох	Уур амьсгалын өөрчлөлттэй холбоотойгоор танай компанийн ашигт эсвэл бүтээгдэхүүн, үйлчилгээний чанарт нөлөөлөлх эрсдэлээс урьдчилсан сэргийлэх (хэрэв урьдчилан сэргийлэх боломжгүй бол) дасан зохицох чиглэлд хэрэгжүүлэх арга хэмжээ, алхмуудыг тодорхойлсон уу?	Тийм/Үгүй	Тийм	Компани нь уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой эрсдэлийг тусгайлан үнэлсэн дасан зохицох төлөвлөгөө одоогоор боловсруулаагүй ч уурхайн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, байгаль орчны эрсдэлийг бууруулах зорилгоор Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хүрээнд усны нөөцийн зохистой хэрэглээ, шүүрлийн усны дахин ашиглалт, биологийн олон янз байдлыг хамгаалах, хот хаягдлын менежмент болон орчны хяналт-шинжилгээний арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байна.
E4.1	Ус	Усны хэрэглээ	Ашигласан усны хэмжээ	м3/л	78,516м.куб	2025 онд нүүрсний зах зээлийн үнийн бууралтын улмаас компанийн уурхайн үйл ажиллагаа тодорхой хугацаанд зогсож, 2025 оны 08 дугаар сарын 17-ны өдрөөс 50 хувийн хучин чадлаар сэргэсэн. Тайлант хугацаанд нийт 78,516м.куб ус ашигласнаас 74,112м.куб-ийг зам талбайн тоосжилт дарахад, шүүрлийн ус, 2,936м.куб-ийг мод усалгаанд, 1,468м.куб-ийг унд, ахуйн хэрэгцээнд ашигласан. Усны хэрэглээг тоолуурын заалт болон тээвэрлэлтийн бүртгэлд үндэслэн тооцож, ус ашигласны төлбөрт нийт 84,6 сая.төгрөг төлсөн.

E4.2		Хэмнэсэн ус	Хэмнэлт, үр ашгийг дээшлүүлснээр хэмнэсэн, боловсруулсан хэмжээ	м3/л	74,112м.куб	Уурхайн үйл ажиллагааны хүрээнд усны хэрэглээг бууруулах, усны нөөцийг үр ашгтай ашиглах зорилгоор 74,112м.куб карьерын шүүрлийн усыг зам талбайн тоосжилт дарахад ашигласан нь энэ хэмжээгээр өөр эх үүсвэрээс авах усны хэрэглээг бууруулсан. Мөн уурхайн технологийн замын тоосжилтыг бууруулах зорилгоор 10 тн хөрс барьцалдуулагч бодисыг усалгаатай хослуулан ашиглаж, усны хэмнэлтийг нэмэгдүүлэн ажилласан.
E4.3		Дахин боловсруулсан ус	Дахин ашигласан болон боловсруулсан усны эзлэх хувь	%	94.4	Уурхайн карьерын шүүрлийн усыг хуримтлуулан зам талбайн тоосжилт дарахад дахин ашиглаж, 2025 онд нийт 74,112м.куб шүүрлийн усыг үйлдвэрлэлийн зориулалтаар ашигласан нь нийт ус ашиглалтын 94.4 хувийг эзэлсэн. Шүүрлийн усны ашиглалтыг насосны тоолуурын заалт болон усалгааны рейсийн бүртгэлээр хянаж, сар бүр баталгаажуулалт хийсэн. Усны түвшин буурсан үед хуримтлагдсан усыг вакум насосоор татан авч, боломжит хэмжээгээр дахин ашигласан.
E4.4		Хаягдал бохир ус цэвэрлэх	Цэвэрлэсэн хаягдал бохир усны хэмжээ	м3/л	0	Тайлант хугацаанд өөрийн эзэмшлийн бохир ус цэвэрлэх байгууламжаар хаягдал бохир ус цэвэршүүлээгүй болно. Уурхайн кемтийн үнд, ахуйн хэрэглээнээс үүссэн бохир усыг Цогтцэций сумын төвлөрсөн ус хангамж, ариутгах татуургын системд холбогдох журмын дагуу нийлүүлж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагаар дамжуулан зайлуулсан. 2025 онд үнд, ахуйн хэрэглээнээс үүссэн нийт 1,468м.куб бохир усыг төвлөрсөн ариутгах татуургын системд нийлүүлсэн.
E5.1	Хатуу хог хаягдал	Хог хаягдал	Нийт ялгаруулсан хог хаягдалын хэмжээ	тонн	408	Компанийн үйл ажиллагаанаас үүссэн хатуу хог хаягдлыг зохицуулах зорилгоор "Тэгш дүүрэн" ОНӨААТҮГ-тай хамтран ажиллаж, хог хаягдлыг түр хадгалах талбайд төвлөрүүлэн бүртгэл, хяналтын дор хадгалсан. Тайлант хугацаанд хуримтлагдсан хог хаягдлыг компанийн хог тээврийн хэрэгсэлээр Цогтцэций сумын төвлөрсөн хог хаягдалын цэгт хүргүүлж, холбогдох байгууллагын үйлчилгээний дагуу зайлуулсан.

E5.2		Дахин боловсруулсан хатуу хог хаягдал	Хог хаягдлыг дахин боловсруулсан хувь	%	0.044	2025 онд хоол үйлдвэрлэлийн үйл ажиллагаанаас үүссэн 180кг хүнсний үлдэгдлийг ажилчдын санаачилгаар гэрийн тэхээвэр амьтны хоол болгон дахин ашиглаж, хог хаягдлыг эх үүсвэр дээр нь бууруулах арга хэмжээ хэрэгжүүлсэн. Цаашид уурхайн үйл ажиллагаанаас үүсэх хог хаягдлын менежментийг сайжруулах, хог хаягдлыг антилан ялгах, дахин ашиглах, дахин боловсруулах болон аюулгүй зайлуулах тогтолцоог хөгжүүлэх зорилгоор тусгай зориулалтын хог хаягдлын төв байгуулах, холбогдох дэд бүтцийг бүрдүүлэх чиглэлээр ажиллаж байна. Энэ хүрээнд орон нутагт хог хаягдлын менежментийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг компаниудтай хамтран ажиллах боломжийг судалж байна.
E5.3		Хорттой хог хаягдал	Хорттой хог хаягдлын нийт хэмжээ (үүнд цахилгаан хэрэгслийн хог орно)	тонн	21.16	Компанийн үйл ажиллагаанаас үүсэх аюултай хог хаягдлыг уурхайн засварын шолын зориулалтын агуулахад түр хадгалж, холбогдох шаардлагын дагуу менежмент хийж байна. Тайлант хугацаанд аюултай хог хаягдлын цуглуулалт, тээвэрлэлт, менежментийн чиглэлээр "Хай би ойл" ХХК-тай гэрээгээр хамтран ажилласан. Цаашид стандартын шаардлагад нийцсэн түр хадгалах талбай байгуулах ажлыг 2026 оны бизнес төлөвлөгөөнд тусгасан. Хаягдлыг антилан авч үзвэл: ашигласан тос (масло) – 6.5 тн, том оврын дутуй – 4 ш (480 кг), самосвалын дутуй – 20 ш (13,000 кг), жижиг оврын дутуй – 42 ш (420 кг), агаар шүүгч – 2 ш (10 кг), аккумулятор – 30 ш (750 кг) байна. Нийт 98 ширхэг хатуу хаягдал үүссэн бөгөөд нийт хаягдлын хэмжээ 21.16 тонн (ашигласан тос 6.5 тн, бусад хаягдал 14.66 тн) гэж тооцоолсон. Тооцоололд ашигласан жин нь хаягдлын төрөл, тоног төхөөрөмжийн хэмжээ, үйлдвэрлэлчийн үзүүлэлтэд үндэслэсэн дундаж утга болно.
E6.1	Биологийн олон янз байдал	Ногоон байгууламж, төлөвлөлт	Байгаль орчны хувьд тогтвортой ашиглаж буй нийтийн эзэмшлийн	%	4.9	Компани нь нийт 29 нэгж талбар бүхий 935.33 га талбайг эзэмшиж, уурхайн үйл ажиллагааны нөлөөллийг бууруулах, ногоон байгууламжийг

		талбай буюу барьсан ногоон байгууламжийн талбайн нийт эзлэх хувь			нэмэгдүүлэх зорилгоор нөхөн сэргээлт, ойжуулалт болон ногоон байгууламжийн ажлыг хэрэгжүүлж байна. Тайлант хугацаанд нийт 46 га талбайд ойжуулалт, ногоон байгууламжийн ажил хэрэгжүүлсэн бөгөөд энэ нь нийт эзэмшлийн талбайн 4.9%-ийг эзэлж байна. Говийн ховор, нэн ховор амьтан, ургамлыг хамгаалах, экосистемийн тэнцвэрийг хадгалах зорилгоор орон нутгийн байгууллагуудтай хамтран байгаль хамгааллын арга хэмжээг хэрэгжүүлж байна. "Чандманы говь" түншлэлийн хүрээнд "Говь түрүү" ХХК, "Уулс ноён" ХХК, "Улз гол" ХХК-тай хамтран "Цэцгий уул"-ын зэрлэг амьтан ундаалах үст цэгийг сэргээн засварлаж, тохижуулсан. Цэцгий хайрхан орчмын зэрлэг амьтдын амьдрах орчныг дэмжих зорилгоор 2024 оны 12 дугаар сараас 2025 оны 03 дугаар сарыг хүртэл хугацаанд 240 боодол өвс, тэжээл, 400 кг хужир, мараа байршуулсан. Энэхүү арга хэмжээ нь "Цэцгий уул"-ын орчимд автомат камерын мониторингийн хүрээнд бүртгэгдсэн хамгааллын ач холбогдол бүхий аргаль (Ovis ammon), янгир (Capra sibirica) зэрэг амьтдын амьдрах орчныг дэмжиж, хамгаалах үйл ажиллагааны нэг хэсэг юм. Мөн говийн унаган ургамлын нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх зорилгоор Номгон сумын Дарсана-Ус багийн Эрдэнэбулаг дахь Мод үржүүлэг, сургалт, судалгаа, инновацийн төвд заг модыг бортогонд үржүүлэх ажлыг хэрэгжүүлж, 2025 онд 8,000 ширхэг тарьц бэлтгэсэн бөгөөд 2026 онд 200,000 ширхэг тарьц тарих бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Байгаль хамгааллын оролцоог нэмэгдүүлэх хүрээнд Цогтцэций сумын 3 сайн дурын байгаль хамгаалагч иргэнийг шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах ажлыг хэрэгжүүлж байна. Компанийн эзэмшил, ашиглалт, үйл ажиллагааны талбай нь улсын болон орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутагтай давхцалгүй бөгөөд биологийн олон янз байдал,
E6.2	Зэрлэг ургамал, амьтдыг хамгаалах	Хамгаалсан зүйлийн тоо	Төрөл зүйлийн тоо	2 зүйл аргаль (Ovis ammon), янгир (Capra sibirica)	
E6.3	Биологийн олон янз байдалд сэргөөр	Тусгай хамгаалалттай газар нутаг, биологийн олон янз байдал, соёлын үнэ цэнэ	%	0	

		нөлөөлж буй үйл ажиллагаа	өндөртэй газар нутгийг эзэмшиж, түрээсэлсэн, удирдаж байгаа эсвэл зэргэлдээх үйл ажиллагааны талбайн нийт талбайд эзлэх хувь			экосистемийн өндөр үнэ цэнэ бүхий хамгаалалтын статустай газар нутагт байрладаггүй болно. Компанийн үйл ажиллагаанаас биологийн олон янз байдлад үзүүлэх нөлөөллийг бууруулах зорилгоор байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллаж байна.
S						
НИЙГМИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ						
S1.1	Хүний нөөц	Хүний нөөцийн тогтвортой байдал	Үндсэн ажилтнуудын ажлын байрны сэлгээний хувь (тухайн онд ажлаасаа гарсан ажилтнуудын тоог ажилласан ажилтнуудын дундаж тоонд хуваах)	%	14.2	2025 онд 9 ажилтан хөдөлмөр эрхлэлтийн харилцааг дуусгавар болгож, ажлаас чөлөөлөгдсөн бол үндсэн ажилтнуудын ажлын байрны сэлгээний хувь 14.2% байна.
S1.2		Шинээр бий болгосон ажлын байр	Өмнөх оны мөн үеэс нэмэгдсэн бүтэн цагийн ажлын байрны тоо	Тоо	2	2025 онд нийт 2 ажлын байрыг шинээр бий болгосон.
S1.3		Сургалт	Нэг ажилтанд ногдох жилийн сургалтын цаг	цаг	11.24	2025 онд компани нийт ажилтнуудад Эерэг хандлага, ажлын бүтээмж, мод үрсэлгээ болон ХАБЭА-ын сургалтыг зохион байгуулсан. Сургалтанд хамрагдалт дунджаар 86%-тай байв.
S2.1	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй (ХАБЭА)	ХАБЭА-ын бодлого	ХАБЭА-ын бодлого, журам бий юу? (тусдаа бодлого, журам эсвэл аль нэг журамд нэгтгэсэн)?	Тийм/Үгүй	Тийм	"Тавантолгой" ХК нь үйлдвэрлэлийн тэргүүн туршлага, дэвшилтэт технологид тулгуурлан, Монгол Улсын хуулийн хүрээнд ажлын байранд тавигдах хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага, стандартыг хангаж, ажилчдыг эрүүл, аюулгүй орчинд ажиллах нөхцөлийг бүрдүүлж, хөдөлмөрийн чадвар алдалтгүй ажиллаж, аюулгүй ажиллагааны хувьд хариуцлагатай компани байхыг зорьж ажилладаг. Компанийн нийт ажилчид нь түүний үнэт зүйл юм. Бодлогын хэрэгжилтийг хангах хүрээнд компанийн үйл ажиллагааны онцлогт нийцүүлэн боловсруулсан 39 журам, заавар, зохицуулалтын баримт бичгийг мөрдөн хэрэгжүүлж байна.

S2.2		Осол аваар	Үйл ажиллагааны явцад гарсан осол аваарын хувь	%	6.4	2025 онд компанийн хэмжээнд нийт 294,716 хүнд цаг буюу 315 хоног хөдөлмөрийн чадвар алдалтгүй ажилласан. Тайлант хугацаанд ХАБЭА-тай холбоотой 17 тохиолдол бүртгэгдсэнээс өмчийн эвдрэл 10, эмнэлгийн тусламж шаардсан гэмтэл 1, хөдөлмөрийн чадвар алдалттай осол 3, галын тохиолдол 3 байв. Үйлдвэрлэлийн ослоос шалтгаалсан нас баралт гараагүй бөгөөд TRIFR үзүүлэлт 0.68 байна. Тайлант онд дунджаар 266 ажилтантай ажилласантай харьцуулахад 6.4%-тай тэнцэж байна.
S2.3		ХАБЭА-ын сургалт	Жилд нэг ажилтанд ногдох дундаж ХАБЭА сургалтын цаг	цаг	7.73	Компани осол, гэмтлийн давтамжийг бууруулах зорилгоор ХАБЭА-н сургалт, ажлын байрны эрсдэлийн үнэлгээ, урьдчилан сэргийлэх хяналт, аюулгүй ажиллагааны хяналт шалгалтыг тогтмол хэрэгжүүлж ажиллаж байна.
S2.4		Эрүүл мэндийн хөтөлбөр	Эрүүл мэндийн үзлэг зэрэг сайн дурын эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдсан ажилчдын тоо, жилээр	хүн	247	2025 онд компанийн үндсэн 176 ажилтан, гэрээт болон туслан гүйцэтгэгчийн 2,478 ажилтан, нийт 2,654 ажилтанд зориулан 20,528 хүнд цагийн ХАБЭА-н сургалт явуулсан.
S3.1	Эрх тэгш байдал	Жендерийн бодлого, журам	Жендерийн бодлого, журам бий юу? (тусдаа нэгтгэсэн)?	Тийм/Үгүй	Үгүй	Нэг ажилтанд ногдох дундаж сургалтын хугацаа 7.73 цаг/жил бөгөөд сургалтаар аюулгүй ажиллагааны дүрэм, журам мөрдөлт, эрсдэлийг таних, ослоос урьдчилан сэргийлэх мэдлэг, дадлыг нэмэгдүүлэх чиглэлд анхаарч ажилласан.
S3.2	Эрх тэгш байдал	Ажлын байрны бэлгийн дарамтын	Бэлгийн дарамтын эсрэг бодлого, журам бий юу? (тусдаа)	Тийм/Үгүй	Тийм	2025 онд эрүүл мэндийн үзлэг, оношилгоонд нийт 247 ажилтан хамрагдсанаас 68 нь эмэгтэй ажилтан байна. Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгийг жил бүр зохион байгуулж, ажилтнуудын эрүүл мэндийн эрсдэлийг эрт илрүүлэх, хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлж байна.
						Ажлын байрны бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, хариуцлага хүлээлгэхтэй холбоотой харилцааг компанийн

	эрэг бодлого, журам	бодлого, журам эсвэл аль нэг журамд нэгтгэсэн)?			Гүйцэтгэх захирлын 2023 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн А/79 дүгээр тушаалаар батлагдсан "Хөдөлмөрийн дотоод журам"-аар зохицуулдаг болно.
S3.3	Ялгаварлан гадуурхалтын эсрэг бодлого, журам	Ялгаварлан гадуурхалтын эсрэг бодлого, журам бий юу? (тусдаа бодлого, журам эсвэл аль нэг журамд нэгтгэсэн)?	Тийм/Үгүй	Тийм	Ялгаварлан гадуурхалтаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, хариуцлага хүлээлгэхтэй холбоотой харилцааг компанийн Гүйцэтгэх захирлын 2023 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн А/79 дүгээр тушаалаар батлагдсан "Хөдөлмөрийн дотоод журам"-аар зохицуулдаг болно.
S3.4	Ажилтнуудын хүйсийн харьцаа	Нийт үндсэн ажилтнуудын тоонд эрэгтэй, эмэгтэй хүйсийн харьцаа	%	Эрэгтэй 73% Эмэгтэй 27%	Компанийн үндсэн ажилтны 73% эрэгтэй, 27% эмэгтэй ажилтан байна.
S3.5	Удирдах зөвлөлийн хувийн хэсгийн харьцаа	Удирдах зөвлөлийн гишүүдийн эрэгтэй, эмэгтэй хүйсийн харьцаа	%	Эрэгтэй 77.8% Эмэгтэй 22.2%	ТУЗ-ын 9 гишүүний 7 буюу 77.8% нь эрэгтэй, 22.2% нь эмэгтэй байна.
S3.6	Гүйцэтгэх удирдлагын хүйсийн харьцаа	Гүйцэтгэх удирдлагын түвшний ажилтнуудын эрэгтэй, эмэгтэй хүйсийн харьцаа	%	Эрэгтэй 86.7% Эмэгтэй 13.3.	Гүйцэтгэх удирдлагын түвшний 15 ажилтны 13 буюу 86.7% нь эрэгтэй, 2 буюу 13.3% нь эмэгтэй ажилтан байна.
S3.7	Дунд болон анхан шатны нэгжийн ажилтнуудын хүйсийн харьцаа	Дунд болон анхан шатны нэгжийн ажилтнуудын эрэгтэй, эмэгтэй хүйсийн харьцаа	%	Эрэгтэй 72.4% Эмэгтэй 27.6%	Анхан шатны нэгжийн нийт 243 ажилтны 176 буюу 72.4% эрэгтэй, 67 буюу 27.6% эмэгтэй ажилтан байна.
S3.8	Жендерт суурилсан цалингийн зөрүү	Эрэгтэй ба эмэгтэй ажилтнуудын дундаж цалингийн харьцаа	харьцаа	Эрэгтэй 4,550,000 Эмэгтэй 3,900,000	
S4.1	Хүртээмжтэй байдал	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бодлого, журам	Тийм/Үгүй	Үгүй	

S4.2		Хөгжлийн бэрхшээлтэй ажилтнууд	Хөгжлийн бэрхшээлтэй ажилтнуудын тоонд нийт эзлэх хувь	%	2.7	2025 оны байдлаар нийт 7 хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллаж байна. Энэ нийт ажилтнуудын 2.7 хувийг эзэлж байна.
S4.3		Оффисын хүрмээмж	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжэй байдлаар шийдсэн оффис, байгууламжтай юу	Тийм/Үгүй	Тийм	Өмнөговь аймгийн Цогтцэций сум дахь компанийн байр, Улаанбаатар хот болон Өмнөговь аймаг дахь Төлөөлөгчийн газар зэрэгт хөгжлийн бэрхшээлтэй иргэд чөлөөтэй нэвтрэх байдлаар барилга байгууламжийн хүртээмжтэй байдлыг хангасан
S4.4		Торгууль	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах тухай хууль тогтоомжийг дагаж мөрдөөгүй	Төгсгөл	0	Байхгүй
S5.1	Нийгмийн хариуцлага ба олон нийтийн оролцоо	Оролцогч талуудын оролцооны засаглал	Оролцогч талуудтай хамтарч ажиллах талаар тусгайлсан бодлого байдаг уу	Тийм/Үгүй	Тийм	"Бид байгалийн эрдэс, баялгийг эрдэм мэдлэг, ур чадвар, үнэт зүйлсээр баяжуулан бүтээгчээр ашиглаж, хувь нийлүүлэгчид болон бусад оролцогч талууддаа бодит үнэ цэнэ бий болгож, улс болон орон нутгийн нийгэм, эдийн засгийн тогтвортой өсөлтөд урт хугацаанд хувь нэмэр оруулж, ажил үүргээ зөв, шударга, хариуцлагатай гүйцэтгэх нь компанийн үнэт зүйлс юм" гэж бүх оролцогч талуудтай харилцах харилцаа, хамтын ажиллагаанд баримтлах бодлогыг тодорхойлсон. Компанийн 51% нь орон нутгийн өмч тул Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай, Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулиудын үйлчлэлд хамаардаг. Үйл ажиллагааны тайланддаа оролцогч болон хамтран ажиллагч талуудын мэдээллийг тусган ажилладаг. Мөн талуудын оролцоог газар зүйн байршлаар хязгаарлахгүй байх зорилгоор Өмнөговь аймаг болон Улаанбаатар хотод тус тус Төлөөлөгчийн газрыг тогтмол ажиллуулж байна.

S5.2		Нийтийн нөлөөллийн үнэлгээ, газар чөлөөлөлтийн бодлого журам	Танай компани нийгэмд нөлөөлөх байдлын бодлого, журамтай юу? (үүнд газар чөлөөлөлт багтана)	Тийм/Үгүй	Тийм	Нийтийн нөлөөллийн үнэлгээг хийлгээгүй ч уул уурхайн олборлох үйл ажиллагаа явуулж байгаагай холбоотойгоор МУ-ын Засгийн газар, уул уурхайн яам, Өмнөговь аймаг болон Цогтцэций сумын ЗДТГ-уудтай хамтран ажиллах гэрээг тогтмол байгуулан ажиллах замаар улс, орон нутгийн иргэд, нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, зөрөг буюу эдийн засгийн дэмжлэг нөлөөллийг нэмэгдүүлэх ара хэмжээг хэрэгжүүлэн ажилладаг. Газар чөлөөлөлтийн асуудлыг зохицуулах тусгайгсан журам байхгүй. Учир нь манай уурхайн үйл ажиллагаа, олборлолт, тээвэрлэлттэй холбоотой их хэмжээгээр чөлөөлөх газар, талбай байхгүй тул холбогдох хуулиудад үндэслэн зохион байгуулж ажилладаг
S5.3		Санал гомдлыг шийдвэрлэх бодлого / журам	Гомдол маргааныг шийдвэрлэх бодлого, механизм бий юу?	Тийм/Үгүй	Тийм	Компани нь 51% орон нутгийн өмч тул Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн хүрээнд гомдол, маргааныг шийдвэрлэн ажиллаж байна. Компанийн Гүйцэтгэх захирлын 2025 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн А/О25 тушаалаар батлагдсан "Гэрээ болон санамж бичиг байгуулах журам"-д ашиг сонирхлын зөрчилтэй гэрээ хэлцэл байгуулахаас урьдчилан сэргийлэх зохицуулалтыг тусгах, мөрдөн ажиллаж байна. Компани Авлигын эсрэг хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль болон ашиг сонирхлын зөрчийг зохицуулах холбогдох хууль тогтоомжийг дагаж мөрдөн ажилладаг болно.
S5.4		Олон нийтэд ил тод мэдээлэх	Танай компанийн үйл ажиллагаа нөлөөж буй иргэдэд мэдээлэл өгөх, санал хүсэлт авч, гомдол шийдвэрлэх тогтолцоо бий юу?	Тийм/Үгүй	Тийм	tavaninfo.go.i.mn веб сайт, info@tavaninfo.go.i.mn и-мэйл хаяг, 95001619 дугаартай утсаар facebook.com/Tavaninfo.go.i.mn цахим хуудсаараа, Улаанбаатар хот болон Өмнөговь дахь Төлөөлөгчийн газрууд, Цогтцэций сум дахь компанийн оффист иргэдийн биеэр болон

					утсаар, цахим зэрэг бүх хэлбэрээр санал голомол гаргах, эргэх холбоо барих нөхцөлийг бүрдүүлсэн. Өмнөговь аймгийн болон Цогтцэций сумын ЗДТГ-тай байгуулсан хамтын ажиллагааны гэрээний хүрээнд жилд 1-ээс доошгүй удаа нээлттэй хаалганы нэгдсэн арга хэмжээнд оролцож мэдээллийг иргэдэд хүргэх, санал томдолог авах ажлыг мөн зохион байгуулж хэвшсэн.
S5.5	Ажилчид, олон нийтийн санал томдолог	Ажилчид болон олон нийтээс ирсэн санал голомдлыг шийдвэрлэсэн хувь	%	100	Тайлант хугацаанд компанийн захиргаанд компанийн үйлдвэрчдийн эвлэлийн хороо болон ажилчдаас 14 санал, томдолог ирүүлснийг хуулийн хугацаанд бүрэн шийдвэрлэсэн. Харилцагч байгууллагууд болон олон нийтийн зүгээс нийт 196 санал, томдолог ирүүлснийг 100 хувь шийдвэрлэсэн байна.
S5.6	Нийгмийн хариуцлагын үйл ажиллагаанд зарцуулсан хөрөнгө оруулалт	Нийгмийн хариуцлагын арга хэмжээ, хөтөлбөрт зарцуулсан хөрөнгө оруулалтын нийт орлоготой эзлэх хувь, ТХЗ-оор ангилсан	%	5	2025 онд нийгмийн хариуцлагын арга хэмжээний зардалд 1.5 тэрбум төгрөгийг зарцуулсан нь нийт хөрөнгө оруулалтын 5 хувийг эзэлж байна.
S6.1	Тогтвортой өрттийн сүлжээний менежмент	Худалдан авалтын бодлого, журам	Тийм/Үгүй	Тийм	Компанийн 51% орон нутгийн өмч тул Худалдан авах ажиллагаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хүрээнд Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр ил тод зохион байгуулдаг, харин шууд худалдан авч болох төсөвт өртөлт багтах худалдан авах ажиллагааг зохицуулах журмыг Гүйцэтгэх захирлын шийдвэрээр баталж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.
S6.2	Дотоодын худалдан авалт	Дотоодын нийлүүлэлтээс авсан худалдан авалтын хувь	%	74	Дотоодын ханган нийлүүлэлтээс авсан худалдан авалт нь 45,7 тэрбум төгрөг буюу 74 хувь байна. Үүнд Цогтцэций сумын болон Өмнөговь аймгийн бусад сумдын ханган нийлүүлэгч багтсан болно.

S6.3	Тогтвортой, ногоон худалдан авалт	Нийт нийлүүлэгчдийн тоонд тогтвортой байгаль нийгмийн шалгуураар сонгогдсон нийлүүлэгчдийн хувь	%	-	Одоогоор ханган нийлүүлэгч ялангуяа уурхайн талбайд ажиллаж байгаа туслан гүйцэтгэгч байгууллагуудад Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль журмыг хэрэгжүүлэн ажиллах шаардлагыг тавьж ажиллаж байна. Байгаль орчин, нийгмийн шалгуурыг гол шалгуур үзүүлэлт болгон хэрэглээгүй байна.
Г ЗАСАГЛАЛТЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ					
G1.1	Компанийн засаглалын бодлого, журам	Шинээр батлагдсан Кодексийн компанийн засаглалын бодлого, журам бий юу, уг журмын тайлагнал хийдэг үү?	Тийм/Үгүй	Үгүй	
G1.2	Удирдах зөвлөлийн хараат бус байдал	Удирдах зөвлөлд хараат бус гишүүдийн суудлын хувь	%	33.3	ТУЗ-ын 9 гишүүний 6 буюу 66.7% нь ердийн гишүүн, 3 буюу 33.3% хараат бус гишүүн байна.
G1.3	Компанийн засаглал	Цөөнх, жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх	Цөөнх, жижиг хувьцаа эзэмшигчдийн эрхийг хамгаалах журам бий юу?	Тийм/Үгүй	Тийм
G2.1	Авлигал болон ёс зүй	Авлига, хээл хахуулийн эсрэг бодлого, журам	Авлигын эсрэг эсвэл Ёс зүйн бодлого, журам бий юу?	Тийм/Үгүй	Тийм
G3.1	Комплаенс	Комплаенсын бодлого	Комплаенсын бодлого, журам бий юу?	Тийм/Үгүй	Тийм
					Тус харилцаа нь Компанийн дүрэм, ТУЗ-ын үйл ажиллагааны журмаар зохицуулагддаг бөгөөд хувьцаа эзэмшигчдэд байгууллагын албан ёсны вэб сайт tavantoigoi.mn болон Монголын хөрөнгийн биржийн mse.mn сайтуудаар дамжуулал нээлттэй мэдээлэл өгч ажиллаж байна. Мөн компаний Цогцэций сум дахь төв оффис, Улаанбаатар болон Өмнөговь аймаг дахь Төлөөлөгчийн газраар мэдээллийг биечлэн хүргэж, тэдний санал хүсэлтийг авч ажилладаг.
					Компанийн Гүйцэтгэх захирлын шийдвэрээр Ёс зүйн хороо байгуулан, Ёс зүйн дүрмийг баталж, шүтэл үлээгчийг хамгаалах тогтолцоот бүрдүүлсэн байна. Мөн Гүйцэтгэх захирлын 2025 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн А/25 тушаалаар батлагдсан "Гэрээ болон санамж бичиг байгуулах журам"-д ашиг сонирхлын зөрчилтэй гэрээ хэлцэл байгуулахаас урьдчилан сэргийлэх зохицуулалтыг тусгах, мөрдөн ажиллаж байна.
					Комплаенсын бодлого нэртэй бие даасан баримт бичиг одоогоор байхгүй боловч компанийн

					"Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам"-аар хууль тогтоомж, компанийн дотоод журам, хөдөлмөрийн аюулгүй байдла, санхүү, худалдан авалт, гэрээний хэрэгжилт зэрэг комплаенсын үндсэн чиглэлүүдэд хяналт хэрэгжүүлэх тогтолцоог бүрдүүлэн ажиллаж байна.
G3.2	Комплаенсын хөтөлбөр	Комплаенсын хөтөлбөр, журам (ажилчдын сургалт, хяналтын зөрчлийн мэдээлэх, сонирхлын сэргийлэх удирдамж, хориг гэх мэт) бий юу	Тийм/Үгүй	Тийм	Дотоод хяналт шалгалтын тогтолцоо, аудит, зөвлөмжийн хэрэгжилтийн хяналт, эрсдэлийг бууруулах арга хэмжээ, ажилтны сургалтыг хөтөлбөр хэрэгжиж байгаа. Мөн компанийн Ёс зүйн дүрэм, Гэрээ болон санамж бичгийг байгуулам журамд авлига, ашиг сонирхлын зөрчил, зөрчил мэдээлэх (whistleblowing), урьдчилан сэргийлэх асуудлуудад тусгасан. Комплаенсын хөтөлбөр нэртэй баримт бичиг одоогоор байхгүй.

F

САЛБАРЫН ОНЦЛОГТОЙ НЭМЭЛТ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД

M11	Нөхөн сэргээлт	Нийт ашиглалтын зориулалттай газартай харьцуулахад нөхөн сэргээлт хийсэн газрын талбайн хувь	%	0.23	Тайлант онд Тавантолгой тосгоны хуучин цэвэрлэх байгууламжийн талбайд халдваргүйтгэл, ариутгал, саармагжуулалт хийж, ус, хөрсний шинжилгээний үр дүнд үндэслэн 0.65 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийсэн. 2025 онд нөхөн сэтгээлт хийсэн талбай нь уурхайн нийт ашиглалтын зөвшөөрөл бүхий 276.9 га талбайтай харьцуулахад 0.23%-ийг эзэлж байна.
	Уул уурхай				Тайлант хугацаанд эрх бүхий хяналтын байгууллагуудын 3 удаагийн хяналт шалгалтаар хууль тогтоомж, стандартын хэрэгжилтийг сайжруулах чиглэлээр нийт 28 заалт бүхий албан шаардлага ирүүлсэн. Үүнд авто зам, геологи, уул уурхай, харилцаа холбоо, газрын харилцаа, байгаль орчны чиглэлээр илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах шаардлагууд багтсан. Хяналт шалгалтын үр дүнд нийт 26.5 сая төгрөгийн торгууль ногдуулсан бөгөөд компанийн зүгээс илэрсэн зөрчлийг арилгах, шаардлагын хэрэгжилтийг хангах, залруулах арга хэмжээг авч ажилласан.
M12	Торгууль	Байгаль орчны зөвшөөрөл, стандарт, дүрэм журмыг дагаж мөрдөөгүйгээс гарсан зөрчлийн тоо	Зөрчлийн тоо	28	

М13		Нүүлгэн шилжүүлэлт	Эдийн засгийн шилжилт хөдөлгөөн, нүүлгэлтэд хамрагдсан иргэдийн тоо	хүн	1	Цогтэций сумын Цагаан-Овоо багийн нутаг дэвсгэр дэх "Зүүн босго"-ын бууцыг эзэмшдэг малчин иргэн Б.Батболдын өвөлжөө нь хаягдаал чулуулгын овоолгын талалтэд ойртсонтой холбоотой нүүлгэн шилжүүлж, нөхөн олговорт 100 сая төгрөг олгохоор тохиролцож, олговрыг олгосон байна.
-----	--	-----------------------	--	-----	---	--